



## ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 06 сарын 23 өдөр

Дугаар А/355

Эрдэнэт

Мөнгөн төлбөрийг тогтоох, чөлөөлөх,  
цэргийн тоо бүртгэлээс хасах,  
Цэргийн дүйцүүлэх албанаас халах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6/а/, 29.2, Цэргийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1.1, 31 дүгээр зүйлийн 2,5,6 дахь заалтууд, Засгийн газрын 2008 оны 49 дүгээр тогтоолын 27 дугаар заалт, Улсын Их Хурлын 2009 оны 33 дугаар тогтоол, Засгийн газрын 2017 оны 2 дугаар сарын 08-ны өдрийн 51 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цэргийн алба хаах насны дээд хязгаарт хүрч 2017 оны эхний хагас жилд цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаасан 98 иргэний нэрсийн жагсаалтыг нэгдүгээр, цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаахаас чөлөөлөгдсөн 112 иргэний нэрсийн жагсаалтыг хоёрдугаар, Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах журам зөрчсөн 1 иргэнийг уг албанаас хасах нэрсийн жагсаалтыг гуравдугаар хавсралтаар баталсугай.

2.Батлан хамгаалах, Хууль зүй, Эрүүл мэнд, спортын сайдын 2016 оны А/115,194,174 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан “Иргэний цэргийн албанд эрүүл мэндээр тэнцүүлэх болон цэргийн алба хаагчийн эрүүл мэндийн байдалд дүгнэлт гаргах журам”-ын дагуу Цэргийн жинхэнэ албаны 2017 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлагаар чөлөөлөгдсөн 17 иргэний нэрсийг жагсаалтыг дөрөвдүгээр хавсралтаар баталж, цэргийн тоо бүртгэлээс чөлөөлөхийг Цэргийн штаб /хурандаа Г.Батсуурь/-т даалгасугай.

3.Цэргийн дүйцүүлэх албыг 2017 оны эхний хагас жилд мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаасан мөнгөн төлбөрийн орлого 59600081 төгрөгийн 50 хувь болох 29775040 төгрөгийг Сангийн яам “Төв төрийн” сан дахь 900000704 дансанд шилжүүлж, орон нутагт үлдэх 50 хувийг Орон нутгийн ерөнхий орлого 100210000910 дансанд шилжүүлж Засгийн газрын 2016 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 215 дугаар тогтоолын дагуу орон нутаг дахь батлан хамгаалах арга хэмжээнд зарцуулахыг Цэргийн штабын дарга /хурандаа Г.Батсуурь/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.БАТЛУТ



D:(Zahiramj) A-4 doc  
0200001614